



Save the Children

Улирал тутмын ЦАХИМ СОНИН

2024 оны 1 дүгээр сар/January 2024

Quarterly E-newsletter

Энэ дугаарт:

- Олон улсын сэтгүүлчид уур амьсгалын өөрчлөлтөд өртөж буй нүүдэлч малчдын амьдралыг сурвалжиллаа
- “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төсөл үр дүн, туршлагаа хуваалцлаа
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаа, үр дүнтэй танилцлаа
- “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургагч багш нарыг бэлтгэлээ
- 2023 оны онцлох үйл явдлууд

Inside the issue:

- International journalists report on the effects of the climate crisis on the lives of nomadic herders
- The “Promoting Inclusive Education for Every Last Child in Mongolia-2” project shares its results
- Projects implemented in Gobisumber province present the results
- Trainers prepared within “Establishing a school-based child protection mechanism in Mongolia” project
- Main events of 2023



ОНЦЛОХ МЭДЭЭ

Хүүхдийг Ивээх Сан АНУ-д төвтэй Денан байгууллагатай хамтран 2022 оноос Говь-Алтай аймгийн Чандмань суманд [эрүүл мэндийн төсөл хэрэгжүүлж](#) байна. Энэхүү төслөөр тус сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, эм тариа авахад дэмжлэг үзүүлж ирлээ. Энэ удаа Хүүхдийг Ивээх Сан болон Говь-Алтай аймгийн Чандмань сумын Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөл хамтран сумын Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн [шинэ авто машин хандивлаж](#), 2023 оны 11 дүгээр сарын 1-нд хүлээлгэн өгөв. Мөн Хүүхдийг Ивээх Сангаас Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн клубын үйл ажиллагаанд зориулан тоног төхөөрөмж өгсөн юм.



HIGHLIGHT NEWS

Save the Children has been implementing a health project in Chandmani Soum of Gobi-Altai province with support and funding from US-based [Denan project](#) since 2022. The project has helped to open a dental cabinet, recruit and train a dentist to enable access to a high-quality dental service in rural communities. This time, Save the Children and the local council of Chandmani soum in Ulaanbaatar [handed over a new ambulance](#) to the soum hospital on November 1, 2023. As well, the Health Club of the Secondary School of the soum received necessary equipment from Save the Children.



ОНЦЛОХ МЭДЭЭ

Олон улсын сэтгүүлчид Хүүхдийг Ивээх Сан (ХИС)-гийн үйл ажиллагаатай танилцаж, малчидтай уулзаж ган, зудын гамшигт үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлт өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцав. Монголчууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ямар хариу арга хэмжээ авч байгаа талаар мэдээ, мэдээлэл бэлтгэх зорилгоор ирсэн сэтгүүлчид 2023 оны 10 дугаар сарын 21-28-нд Өвөрхангай аймгийн төв болон сумдад ажиллаж, орон нутгийн удирдлагатай уулзалт хийж, [ХИС-гийн үйл ажиллагаатай танилцав](#). Сэтгүүлчдийн багт Хүүхдийг Ивээх Сангийн Австрали, Япон болон олон улсын эвслийн хэвлэл мэдээллийн захирал, менежер, ажилтнууд болон АНУ-д төвтэй HuffPost мэдээллийн вэбсайт, Их Британийн “The Guardian” сонин, Австралийн ABC News сүвгийн сэтгүүлч, зураглаач зэрэг хүмүүс багтжээ.



HIGHLIGHT NEWS

International journalists and Save the Children’s international staff visited Mongolia to put a spotlight on how climate change is impacting children in Mongolia’s herding communities ahead of COP. From October 21 to 28, 2023, [the journalists worked in Uvurkhangai province](#) and Ulaanbaatar city to get deeper insights on how herders cope with changing weather and respond to climate crisis. The international team consisted of Media Director, manager and staff from Save the Children Australia, Save the Children Japan and Save the Children International, as well as journalists from prominent media agencies such as HuffPost in the United States, the Guardian in the UK, and ABC News in Australia.



ОЛОН УЛСЫН СЭТГҮҮЛЧДИЙН ГАРГАСАН НИЙТЛЭЛҮҮДИЙГ ЭНДЭЭС ҮЗЭХ БОЛОМЖТОЙ MEDIA COVERAGE FROM THE TRIP:

- [Dust, hail and bank loans: the Mongolian herders facing life without grass | Global development | The Guardian](#)
- [Video/TV: https://www.youtube.com/watch?v=FSyDMRrjafk](https://www.youtube.com/watch?v=FSyDMRrjafk)
- [Online: https://www.abc.net.au/news/2023-12-10/at-the-mercy-of-mongolia-s-changing-climate/103053708](https://www.abc.net.au/news/2023-12-10/at-the-mercy-of-mongolia-s-changing-climate/103053708)
- [Mongolia’s Ancient Culture Under Threat From Climate Change | HuffPost UK News \(huffingtonpost.co.uk\)](#)
- [Mongolia’s Displaced Nomads And The Cost Of City Life | HuffPost UK World News \(huffingtonpost.co.uk\)](#)
- [Children of Mongolian nomads forced to abandon herding by climate change | Save the Children International](#)



ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийг 2020 оноос Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт хэрэгжүүлж байгаа билээ. Төслийн хүрээнд хосолсон ESEL сургалтын чиглүүлэгч багш бэлтгэх [сургалтыг](#) 2023 оны 10 дугаар сарын 30-31-нд Улаанбаатар хотод зохион байгуулав. Сургалтад зорилтот 5 аймгийн НТСТ-ийн захирал, 10 сумын ESEL сургалтын болон НТСТ-ийн багш нар төслийн салбарын ажилтнууд, төслийн Улаанбаатар хотын баг, хамтрагч байгууллагын төлөөллүүд зэрэг 40 хүн оролцлоо.




NEWS

Save the Children has been implementing the project [“Entrepreneurship-focused socio-emotional skills for the most vulnerable youth in rural Mongolia”](#) in the provinces of Khovd, Zavkhan, Uvurkhangai, Gobi-sumber and Sukhbaatar since 2020. As part of the project, a [training for trainers](#) in blended learning was organized in October 30-31, 2023 in Ulaanbaatar. A total of 40 individuals participated in this training, including project staff, principals of the Lifelong Education Centers (LLEC) in five target provinces, ESEL trainers, and teachers of the LLECs of ten soums.



ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” [төслөөс](#) “Тэгш хамруулах боловсрол” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг 2023 оны 10 дугаар сарын 26-нд нийслэлийн Баянзүрх дүүргийн 79-р сургуулийн урлагийн зааланд зохион байгууллаа. Энэхүү [арга хэмжээнд](#) ирсэн эцэг эх, багш нар, хүүхэд, залуучууд мэргэжлийн байгууллагуудаас тэгш хамруулах боловсролын талаар үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөгөө авсан юм. Энэхүү арга хэмжээний үеэр 300 гаруй багш, эцэг эх, сурагчид өөрсдийн сонирхсон чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас мэдээлэл, зөвлөгөө авч тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, харилцах талаар мэдлэг ойлголтоо бэхжүүлэв.




NEWS

The [“Promoting Inclusive Education for Every Last Child in Mongolia-2”](#) project implemented by Save the Children organized an [awareness-raising event](#) on Inclusive Education for the public on October 26, 2023, in the art hall of the 79th school of Bayanzurkh district. Parents, teachers, children, and youth who attended the event received free information and advice on inclusive education from professional organizations. During this event, more than 300 teachers, parents, and students received information and advice from professionals in their areas of interest.



ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй [“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл](#), ФАРО сан ТББ-тай хамтран “Нөлөөлье, өөрчилье” сэдвээр өсвөр үеийнхний дунд ХАКАТОН зохион байгууллаа. Гол зорилго нь хүүхдүүд өөрсдөө цахим орчинд тэдэнд ямар аюул, эрсдэлүүд байгааг тодорхойлж, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хамгаалах арга шийдлийг гаргаж ирж, түүнийг нөлөөллийн ажил болгон хэрэгжүүлэх юм.

[“Нөлөөлье, өөрчилье” хакатон](#) 2023 оны 11 дүгээр сарын 6-11-нд Hub Innovation төвд зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Нийт 9 дүүрэг, 12 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 13-17 насны 628 оролцогч бүртгүүлснээс, эхний шатанд 10 баг шалгарсан байна.



NEWS

FARO Foundation NGO and the project [“Protecting Girls from Violence and Exploitation in Mongolia” project](#) implemented by the Save the Children jointly organized the hackathon event among young people on the theme “Let’s Influence and Change”. The main goal of the event was to help children identify the dangers and risks they face in the digital environment, develop solutions to prevent and protect themselves from them, and implement these solutions in the form of advocacy activity.

The [“Let’s Influence and Change” hackathon](#) was organized between November 6 and 11, 2023, at the Hub Innovation Center and released the results. A total of 628 participants aged 13-17 from general education schools of 9 districts in Ulaanbaatar and 12 aimags registered for participation.



ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Хүүхдийг Ивээх Сан [“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”](#) төслийг Улаанбаатар хот болон Говь-Алтай, Ховд аймгуудад 2023 оноос хэрэгжүүлж байгаа билээ. Төсөл хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын 10 сургуулийн төлөөлөл 2023 оны 12 дугаар сарын 1-8-ны өдрүүдэд Ховд аймгийн Жаргалант сумын 1-р сургууль, Дарви сумын дунд сургууль, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4-р сургууль, Дарив сумын дунд сургуулиудаар зочилж, сургуулиудын баг хамт олонтой сургуулийн орчны хүүхэд хамгааллыг сайжруулах болон удирдлага менежментийн чиглэлээр [харилцан туршлагаа солилцов](#).



NEWS

Save the Children is actively implementing the [“Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia”](#) project across Ulaanbaatar city and the Gobi-Altai and Khovd provinces in 2023-2025. Recently, representatives from 10 schools in Ulaanbaatar involved in the initiative embarked on a [knowledge-sharing journey](#). They visited Jargalant 1st School, Darvi Secondary School, Yesonbulag Sum in Gobi-Altai province, and Dariv Sum Secondary Schools between December 1st and 8th, 2023.

 **ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд жил бүрийн шинэ оныг угтан сайн үйлсийн аян зохион байгуулдаг уламжлалтай билээ. Энэ удаа “Хамтдаа-2023” сайн үйлсийн аянаараа Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн зорилтот 12 сургуулийн тусгай хэрэгцээтэй болон гэртээ байдаг 250 гаруй хүүхдэд 2023 оны 12 дугаар сарын 21-нд [шинэ жилийн бэлэг өглөө](#). Хүүхдийг Ивээх Сантай хамтран ажиллаж, хүүхэд бүрийн хүсэн хүлээдэг шинэ жилийн бэлэг бэлтгэхэд хандив өгч, ивээн тэтгэсэн Микро Сити ХХК, Зайвар Алтай ХХК, Гэрэлт Таван Эрдэнэ ХХК, Хаан Палас ХХК (Кемпински зочид буудал), Эм Эм Си Жи ХХК, Плас Медиа ХХК, Импресс Колор ХХК, Ди Ди Принт ХХК, Арвин Гоёл ХХК, Флекс Солюшнс ХХК, МЭК ХХК, Коёот Трэйд ХХК, Би Эс Би ХХК, Блумли ХХК, Практикал даатгал ХХК, Морьт тайж ХХК зэрэг бүх аж ахуйн нэгждээ талархлаа илэрхийлж, сайн сайхныг хүсье.

 **NEWS**

We, at Save the Children in Mongolia, have a tradition to undertake a charity activity on the New Year's Eve. This time, through our campaign “Together-2023”, we raised funds and delivered New Year gifts to more than 250 children with special needs on 21 December 2023. These children are stay-at-home kids or students of target 12 public schools under the [“Promoting Inclusive Education for Every Last Child in Mongolia-2” project](#). We highly appreciate following companies and organizations that donated to this charity campaign: Micro City LLC, Zaivar Altai LLC, Gerelt Tavan Erdene LLC, Kempinski Hotel Khan Palace LLC, MMCG LLC, Plus Media LLC, Impress Color LLC, DD Print LLC, Arvin Goyol LLC, Flex Solutions Group LLC, MEC LLC, Koyot Trade LLC, BSB Corporation LLC, Bloomley LLC, “Practical Daatgal” LLC, and Morit Taj LLC.

 **ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ**


Японы Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын хөтөлбөр хариуцсан захирал Майко Фужи 2023 оны 12 сарын 11-15-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийлээ. Тус айлчлалын хүрээнд түүнийг Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалалын Дэд сайд С.Зулпхар [хүлээн авч уулзлаа](#). Уулзалтад Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай, ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер Э.Цолмон, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершипийн боловсрол олгох төслийн менежер Ё.Нямдаваа нар болон албаны бусад хүмүүс оролцов.

 **NEWS**

The Deputy Minister of Labor and Social Protection of Mongolia, Mr. S. Zulphar, warmly welcomed Mrs. Maiko Fujii, Director of International Programs at Save the Children Japan, during her official working visit to Mongolia from December 11-15, 2023. [The meeting](#) was attended by Mrs. N. Bayarmaa, Head of the Family Policy Implementation and Coordination Department of the MLSP, Mr. L. Bayan-Altai, Country Manager of Save the Children in Mongolia, Mrs. E. Tsolmon, the Child Protection and Child Rights Governance Programs Manager and Mr. Yo. Nyamdavaa, Manager for “Entrepreneurship-focused Socio-emotional skills for the most vulnerable youth in rural Mongolia” project of Save the Children in Mongolia and other officials.

ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

УИХ-ын гишүүн Ц.Туваан Японы Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын хөтөлбөр хариуцсан захирал Майко Фужи, Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай нарыг 2023 оны 12-р сарын 13-нд [хүлээн авч уулзав](#). Хүүхдийг Ивээх Сан нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаагаар тэргүүлэх байр сууринд явж байгаа байгууллага хэмээн УИХ-ын гишүүн Ц.Туваан хэллээ. Уулзалтад оролцогсад Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах болон хүмүүнлэгийн үйл ажиллагааны чиглэлээр санал солилцов.



NEWS

Mrs. Maiko Fujii, Director of International Programs, Save the Children Japan and Mr. L. Bayan-Altai, Country Manager of Save the Children in Mongolia [paid a courtesy visit](#) to Mr. Ts.Tuvaan, Member of the Parliament of Mongolia on 13th December, 2023 in the Parliament House. Mr. Ts.Tuvaan acknowledged that Save the Children has been and continue to be one of the most important partners among all other international organizations being at the forefront of many positive changes in the country. The meeting participants exchanged their opinions in child protection, child rights sectors and humanitarian interventions in the country.

ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой [“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төсөл](#) 2022 оноос хэрэгжиж байгаа билээ. Уг төслийг “Боловсролын Дэлхийн Түншлэл” (GPE) байгууллагаас боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгон үзүүлсэн буцалтгүй тусламжийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яам хэрэгжүүлж байна. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн Удирдах хорооны ээлжит хурал 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр боллоо. Хурлаар төслийн 2023 оны төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсож, ажлаа дүгнэж, ирэх 2024 оны ажлын төлөвлөгөөгөө ярилцлаа.



NEWS

Save the Children in Mongolia is working as a grant agent under the [“Enabling Equity to Advance Learning” project](#) funded by the Global Partnership for Education (GPE) and being implemented by the Ministry of Education and Science for three years (2022-2025). The project’s Steering Committee Meeting was held on 27 December 2023, where participants concluded the implementation and achievements of the project and discussed plans for 2024.



ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧ МЭДЭЭ

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” [ТӨСЛИЙН](#) удирдах зөвлөлийн гишүүд, хамтрагч талуудын төлөөлөл 2023 оны 11 дүгээр сарын 16-18-нд Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаа, [үр дүнтэй танилцлаа](#).

NEWS

“Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” [project's](#) management board and representatives of the partner organizations [traveled to Sumer soum](#) of Gobisumber aimag to learn about the activities and results of the projects implemented in that soum on November 16-18, 2023.

АМЖИЛТЫН ТҮҮХ SUCCESS STORY

Сарнай өнөөдөр өөрийгөө эргэн харахад хүн бүртэй нийтэч, нээлттэй харилцаж, шинийг эрэлхийлэх, сурч мэдэх хүсэл тэмүүлэл дүүрэн, олон найзтай болж, өөрийгөө сайнаар илэрхийлж, бусдыг хүндэтгэдэг чадвартай болсон гэдэгтээ итгэлтэй байна. Түүнд цаашдаа ч илүү ихийг сурч, хөгжих хүсэл зорилго ч дүүрэн байгаа.

[Түүний түүхийг эндээс уншаарай.](#)

Sarnai is becoming adept at expressing herself effectively and maintains a deep respect for others. Her determination to learn more and continue evolving in the future is unwavering.

[Read her story here.](#)



ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН 2023 ОНЫ ОНЦЛОХ 10 АМЖИЛТ

2023 TOP 10 ACHIEVEMENTS OF SAVE THE CHILDREN IN MONGOLIA

1 СУРГУУЛЬД ТҮШИГЛЭЖ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛЖ БАЙНА

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжүүлж эхлэв. Энэхүү төслөөр сургуульд суурилсан хүүхэд хамгааллын механизмыг хөгжүүлснээр үр дүнтэй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах хамтын ажиллагааны загвар бий болгох зорилготой юм. Төсөлд Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн нийт 14 сургууль, 14 хамтарсан баг хамрагдаж байна.

STRENGTHENING SCHOOL-BASED CHILD PROTECTION SYSTEM

Save the Children began implementing the “Establishing school-based child protection mechanism in Mongolia” project. The project aims to create a collaborative model for effective prevention, early detection and response through the development of school-based child protection mechanisms. A total of 14 schools and 14 child protection multidisciplinary teams from Khan-Uul, Bayangol, Chingeltei, Sukhbaatar, Bayanzurkh districts of Ulaanbaatar city and Gobi-Altai and Khovd aimags are participating in this project.




2

ЗУДАД НЭРВЭГДСЭН МАЛЧИД, МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАВ

Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөр 321,000 ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлээ. Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгийн 22 сумын зудад өртсөн 1,230 малчин өрхөд малын тэжээл, бэлэн мөнгөний тусламж үзүүлэв. Мөн Завхан, Говь-Алтай, Ховд аймгийн 15 сумын дотуур байранд амьдардаг малчны 1030 хүүхэд болон сумын төвийн айлд амьдардаг малчны 644 хүүхдэд эрүүл ахуйн багц, сэтгэл зүйн анхны тусламжийн гарын авлага, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой зорилтот бүлгийн 300 хүүхдэд дулаан гутал өглөө. Мөн 15 сумын дотуур байр тус бүрд 400 ширхэг хөнжил, гудас, цагаан хэрэгсэл зэрэг зөөлөн эдлэлээр туслав.

HERDERS AND CHILDREN FROM HERDER FAMILIES AFFECTED BY DZUD RECEIVED ASSISTANCE

Save the Children has implemented the humanitarian aid program receiving \$321,000 in funding. Animal feed and cash assistance were provided to 1,230 herder households in 22 soums of Khovd, Zavkhan, Gobi-Altai, Bayankhongor, and Tuv aimags affected by the dzud disaster. Also, we distributed hygiene kits and psychological first aid manuals to 1030 children from herder families living in school dormitories in 15 soums of Zavkhan, Gobi-Altai, and Khovd aimags, and 644 children staying with the families residing in centers of the same target soums. In addition, 300 children from vulnerable families with incomes below the subsistence minimum received warm shoes. Also, 400 blankets, mattresses, bed linen and sheets were provided to each of 15 soum dormitories.



3

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫН СУДАЛГАА ХИЙЛЭЭ

Хүүхдийг Ивээх Сан гийн хэрэгжүүлж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд ММCG судалгааны байгууллагатай хамтран насанд хүрэгчдийн Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгааг Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн удирдамжаар анх удаа хийлээ. Судалгааны тайланг “Охидыг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах нь”, “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслүүдийн удирдах зөвлөлд танилцуулж, олон нийтэд нээлттэйгээр Хүүхдийг Ивээх Сангийн цахим хуудаснаа байршуулав.

THE STUDY OF KNOWLEDGE, ATTITUDES AND PRACTICES CONDUCTED IN MONGOLIA

In May 2023, Save the Children successfully concluded a comprehensive KAP survey as part of the project “Protecting Girls from Violence and Exploitation in Mongolia.” This research initiative, conducted in collaboration with the esteemed research organization MMCG, focused on the implementation of a meticulous research methodology developed by Save the Children International, addressing the knowledge, attitudes, and practices of adults about child protection. The outcomes of this survey have been formally presented to the members of the Steering Committee overseeing both the “Protecting Girls from Violence and Exploitation in Mongolia” project and the “Establishing School-based Child Protection Mechanism in Mongolia” project. The insights gleaned from this research endeavor are poised to significantly contribute to the ongoing efforts to protect girls from violence and exploitation in Mongolia. The comprehensive report, encapsulating the methodologies, findings, and recommendations, is now available to the public and can be accessed via our official website. This transparent dissemination ensures that the broader community and stakeholders benefit from the valuable insights garnered through this research initiative.

4

ҮЕРТ ӨРТСӨН ИРГЭД, ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАВ

Улаанбаатар хотод 2023 оны 8 дугаар сарын 5-нд хүчтэй аадар бороо орж, Баянзүрх дүүргийн 21, 27, 29-р хорооны иргэд өртөж, эд материал, сэтгэл санааны хохирол амссан байна. Гамшигт өртсөн Баянзүрх дүүргийн гэр бүл, хүүхдүүдэд туслах 110 мянган ам.долларын төсөл хэрэгжүүлж, нийт 1237 хүнд, үүнээс 403 нь хүүхдэд тусламж хүргэв. Үүнд 288 хүүхдэд сурагчийн дүрэмт хувцас, биеийн тамирын спорт гутал, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд цүнх, хичээлийн хэрэгсэл, 278 хүүхдэд хоёр төрлийн мультивитамин өглөө. Мөн энэ гурван хорооны 25 өрхөд таван ханатай гэр, 108 өрхөд 10 хүртэлх насны хүүхдийн хөнжил, гудас, даавуу, дэр бүхий багц, 125 өрхөд хөнжил, 125 өрхөд ус зөөвөрлөх 50 литрийн сав, 250 өрхөд ахуйн халдваргүйтгэлийн бодисоор туслав. Түүнчлэн хүүхэд, насанд хүрэгчдэд сэтгэлзүйн анхны тусламж болон бүлгийн сэтгэл заслын сургалт явуулав.

PROVIDED AID TO PEOPLE AND CHILDREN AFFECTED BY THE FLOOD

On August 5, 2023, a heavy rainfall occurred Ulaanbaatar, and the subsequent flooding caused material and emotional damage to the residents of the 21st, 27th and 29th khoroo of Bayanzurkh district. Save the Children implemented a \$110,000 project to assist families and children affected by flooding in Bayanzurkh district. 1,237 people received assistance, including 403 children. Among them, 288 children received school uniforms and sports shoes, school students and kindergarten children received school bags and supplies, and 278 children received two types of multivitamins. We also donated five-walled gers to 25 families from these three khoros; blankets, mattresses, sheets, and pillows for children up to 10 years of age to 108 families; blankets to 125 families; 50-liter containers for storing and carrying water to 125 families, and household disinfectants to 250 families. In addition, trainings on psychological first aid and group psychotherapy were organized for children and adults.



5


МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРТ ESEL БАГТАВ

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А-278 тоот тушаалаар “Энтерпренершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалт Политехник коллеж, Мэргэжлийн боловсролын сургуулийн Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн үндсэн нэг судлагдахуун боллоо. ESEL нь Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтерпренершип боловсрол” олгох төслийн сургалтын хөтөлбөр юм.

ESEL INCLUDED IN THE MAIN CURRICULUM FOR VOCATIONAL EDUCATION

According to Order No. A-278 of the Minister of Education and Science of Mongolia dated June 28, 2023, the Entrepreneurship Focused Socio-Emotional Skills Learning (ESEL) program has become one of the core subjects of vocational education curriculum in polytechnical colleges and vocational education schools. ESEL is a training program of the Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia project implemented by the Save the Children.

6

ГЭМТЛИЙН ҮЕИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАВ

“Сумдын эмнэлэгт хүүхдийн гэмтлийн үеийн яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах, бэхжүүлэх төсөл”-ийг Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Алтай, Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд хэрэгжүүлэв. Төслөөр хөдөө орон нутгийн хүүхдүүдийн гэмтэл бэртлийн үеийн бэлэн байдал, тусламж үйлчилгээг сайжруулах, гэмтлийн шалтгаант нас баралт, өвчлөл, хүндрэлийг бууруулах зорилготой байв. Төслийн хүрээнд осол гэмтлийн үед ашиглах дамнуурга, хүзүү, нуруу, мөчдийн чиг гэх мэтийн нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгслүүдийг иж бүрнээр нь сумдын эрүүл мэндийн төвүүдэд өглөө.



STRENGTHENED EMERGENCY RESPONSE CAPACITIES DURING TRAUMA

“Strengthening capacity of pediatric trauma care and child first aid responses in rural areas” project has been implemented in Erdene and Altai soums of Gobi-Altai aimag and Saikhan-Ovoo soum of Dundgobi aimag. The project aimed to increase preparedness and improve trauma care for children in rural areas and to reduce mortality, morbidity and complications from trauma. As part of the project, a full set of necessary medical equipment such as stretchers, splints for neck, spine and limbs was delivered to soum health centers.



7

ЭНТРЕПЕНЕР СУРАГЧДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН БОЛОВ

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепeneurшип боловсрол олгох” төслөөс тэтгэлэг авч бичил төсөл хэрэгжүүлж буй сурагчдын туршлага солилцох үндэсний чуулганыг олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд төсөл хэрэгжиж буй зорилтот сумдын 39 сургууль бүрээс 2 төлөөлөл, нийт 78 хүүхэд, 8 багш оролцсон байна.

NATIONAL CONFERENCE ON EXCHANGE OF EXPERIENCE OF STUDENT ENTREPRENEURS ORGANIZED

A national conference was held at the Nairamdal International Children's Camp to share experiences of students implementing micro-projects with grants from the project “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia”. Two representatives from each of the 39 target soum schools attended the event, totaling 78 children and 8 teachers.

8

ОЛОН УЛСЫН СЭТГҮҮЛЧДИЙН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Хүүхдийг Ивээх Сангийн урилгаар олон улсын сэтгүүлчид Монголд ажиллаж, хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ малчидтай уулзаж ган, зудын гамшигт үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлт өдөр тутмын амьдралд нь хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцлага, сурвалжлага хийв. Сэтгүүлчдийн багт Хүүхдийг Ивээх Сангийн Австрали, Япон болон олон улсын эвслийн хэвлэл мэдээллийн захирал, менежер, ажилтнууд болон АНУ-д төвтэй Huffpost мэдээллийн вэбсайт, Их Британийн “Guardian” сонин, Австралийн ABC News сувгийн сэтгүүлч, зураглаач зэрэг хүмүүс багтав.

ORGANIZED A TRIP FOR INTERNATIONAL JOURNALISTS

At the invitation of Save the Children, international journalists visited Mongolia to learn about the program, meet with herders and conduct interviews and reports on how drought, dzud and climate change are affecting daily life. The team of journalists included media directors, managers and staff from Save the Children’s Australian, Japanese and international coalitions, as well as reporters and cameramen from the US-based news site Huffpost, Britain’s Guardian newspaper and Australia’s ABC News.





9

“ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ ҮР ДҮН, ТУРШЛАГАА ХУВААЛЦЛАА

“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн үр дүн, туршлагыг хуваалцах “Тэгш хамруулах боловсрол” үндэсний семинарыг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Үндэсний семинарт 21 аймаг, нийслэлийн дүүргүүдийн Боловсролын газар, хэлтсийн тэгш хамруулах боловсрол хариуцсан 32 мэргэжилтэн оролцлоо. Семинарт оролцогчид төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модуль, гарын авлагуудтай танилцсанаас гадна зорилтот сургуулиудад зочилж төслийн бодит туршлага, үр дүнтэй танилцав.

THE PROMOTING INCLUSIVE EDUCATION FOR EVERY LAST CHILD IN MONGOLIA-2 PROJECT SHARED ITS RESULTS AND BEST PRACTICES

The national workshop on “Inclusive Education” was organized in Ulaanbaatar to share results and best practices under the project “Promoting Inclusive Education for Every Last Child in Mongolia-2”. The national workshop was attended by 32 inclusive education specialists from the education departments of 21 aimags and Ulaanbaatar city districts. The workshop participants learned about the training modules and manuals developed under the project, visited target schools and familiarized themselves with the best practices and achievements of the project.

10

“ЧИ ГАНЦААРАА БИШ” СОШИАЛ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ДАВХАРДСАН ТООГООР 37 САЯ ӨСВӨР НАСНЫ ОХИД БОЛОН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ НАРТ ХҮРЭВ

Аливаа урьдчилан сэргийлэх мэдээллийг зорилтот бүлэгт хүргэхдээ, тэдний сонирхол, үзэл бодлыг судалсан судалгаанд тулгуурлах нь өндөр үр дүнтэй болохыг “Чи ганцаараа биш” нөлөөллийн ажил харууллаа. Ингэхдээ зорилтот бүлэг тус бүрээр ангилан, охид, эцэг эх, асран хамгаалагч болон мэргэжилтнүүдэд зориулан 3 үе шаттай зохион байгуулж байна.

THE “YOU’RE NOT ALONE” SOCIAL MEDIA CAMPAIGN REACHED OVER 37 MILLION PEOPLE INCLUDING TEEN GIRLS, THEIR PARENTS AND CAREGIVERS

The social media campaign “You are not alone” has shown that it is very effective to use the results of surveys examining their interests and opinions when communicating any information about prevention to the target group. The campaign is divided for each target group and organized in 3 phases for girls, parents, guardians and specialists.



ИРЭХ УЛИРАЛД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд бүтээсэн “Даван туулагч” баримтат уран сайхны киноны нээлт 2024 оны 1-р сард нээлтээ хийнэ.
- “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд 2024 оны 1-р сард “Би найзаа дэмжинэ сургалт” Улаанбаатар хот, Ховд болон Говь-Алтай аймагт болно.
- “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд мэргэжлийн боловсролын сургуулиудад зориулсан гарын авлагуудыг хэвлэн гаргана. Мөн төслийн эцсийн үр дүнгийн судалгааны тайланг олон нийтийн хүртээл болгоно.
- “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн хүрээнд 2024 оны 3 дугаар сард багш нарын туршлага солилцох уулзалт болно. Мөн “Хамтдаа” сошиал медиа кампанит ажлыг зохион байгуулна.
- “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд хосолсон сургалтын 4 модулийг зорилтот 50 сургуульд хэрэгжүүлнэ.

UPCOMING EVENTS FOR THE NEXT QUARTER

- A documentary, titled “Survivor” will be launched in January 2024 within the “Protecting girls from violence and exploitation in Mongolia” project.
- Series of training sessions, named “I support my friend” will be held in Ulaanbaatar, Gobi-Altai and Khovd provinces within the “Establishing school-based child protection mechanism in Mongolia”.
- ESEL training package for TVET schools will be published within the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project. Also, ESEL Endline Survey findings will be released.
- Teacher exchange event will be held in March 2024 within the “Promoting Inclusive Education for Every Last Child in Mongolia-2” project. A social media campaign, titled “Together” will be launched in February 2024.
- Four blended learning modules will be piloted in 50 blended learning target schools within the “Enabling Equity to Advance Learning” project.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Бодит дэвшил гаргах замаар хүүхдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах

АЛСЫН ХАРАА:

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох

OUR MISSION:

Our mission is to inspire breakthroughs in the way the world treats children and to achieve immediate and lasting change in their lives

OUR VISION:

Our vision is a world in which every child attains the right to survival, protection, development and participation

ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД | THEMATIC PROGRAM AREAS OF SAVE THE CHILDREN:



Боловсрол
Education



Хүүхэд хамгаалал
Child Protection



Хүүхдийн эрхийн засаглал
Child Rights Governance



Хүүхдийн ядуурал
Child Poverty



Эрүүл мэнд
Health



Хүмүүнлэгийн яаралтай тусламж
Humanitarian Assistance



🏠 Ulaanbaatar, Chingeltei district, Arizona center, 4th floor
☎ +976-11-329365 | 📠 +976-11-329361
✉ mongolia.secretary@savethechildren.org



www.savethechildren.mn



Save the Children in Mongolia



Save the Children MN



[Savethechildren.mongolia](https://www.instagram.com/savethechildren.mongolia)



Save the Children in Mongolia